

**УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН ХӨВӨЛТИЙН УЛИРЛЫН НЭЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ХҮРЭЭНД "УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА" СЭДЭВТ ХАМТАРСАН  
СУРГАЛТ, СЕМИНАР ТОМИЛОЛТООР АЖИЛЛАСАН АЖЛЫН ТАЙЛАН**

2026.06.25-ны өдөр

Улаанбаатар хот

**Нэг.Зорилго**

1.1.Усан замын тээврийн хөвөлтийн улирлын нээлтийн арга хэмжээний хүрээнд усан замын тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд Усан замын тээврийн тухай хууль тогтоомжийг сурталчлан таниулах, хүний амь нас, эрүүл мэнд, байгаль орчинд учруулж болзошгүй аливаа хүчин зүйлс, осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр заавар зөвлөмж өгөх зорилгоор "Усан замын тээврийн аюулгүй ажиллагаа" сэдэвт хамтарсан сургалт, семинарыг зохион байгуулах.

**Хоёр.Томилолтоор ажиллах улс, хот, орон нутгийн нэр, хугацаа**

2.1.Хөвсгөл аймгийн Хатгал тосгонд 2026 оны 06 дугаар сарын 17-19-ний өдрүүдэд дуустал.

**Гурав.Албан томилолтыг санхүүжүүлэх эх үүсвэр**

3.1.Монгол Улсын Далайн захиргааны 2026 оны үйл ажиллагааны орлого, зарлагын төлөвлөгөөнд тусгагдсан төсөвт зардлаас.

**Дөрөв.Томилолтоор ажиллах бүрэлдэхүүн**

4.1.Гадаад харилцаа, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн Э.Номин, Хүний нөөц, сургалт хариуцсан мэргэжилтэн Д.Энхмандах, Дотоод үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтэн Ш.Нарангэрэл, Жолооч Ч.Хангай нарын бүрэлдэхүүнтэй.

**Тав.Хийж гүйцэтгэсэн ажил**

Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын Хатгал тосгон дахь "Далайн түрлэг" жуулчны баазад Монгол Улсын Далайн захиргаанаас зохион байгуулсан "Усан замын тээврийн аюулгүй ажиллагаа" сэдэвт хамтарсан сургалт, семинарт оролцож, зохион байгуулалтын болон холбогдох чиглэлээр ажиллав.

Сургалт, семинарт Зам, тээврийн яам, Хөвсгөл аймаг, орон нутгийн төрийн захиргааны байгууллага, Хөвсгөлийн тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа, Хөвсгөл нуур-Эгийн голын сав газрын захиргаа, усан замын тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн төлөөлөл оролцож, усан замын тээврийн аюулгүй ажиллагаа, усны ослоос урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, усан орчныг хамгаалах чиглэлээр мэдээлэл, зөвлөмж авч, санал солилцов.

Сургалтын эхэнд Монгол Улсын Далайн захиргааны дарга М.Өлзий, Зам, тээврийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Далай ашиглалт, усан замын тээврийн бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн аймаг, орон нутгийн захиргааны байгууллагын төлөөлөл оролцож, арга хэмжээг нээж, усан замын тээврийн аюулгүй ажиллагааг хангах, хөвөлтийн улиралд хууль тогтоомжийг мөрдөж ажиллахын ач холбогдлыг онцолсон.

Сургалтын үндсэн илтгэл, мэдээллийн хүрээнд Монгол Улсын Далайн захиргааны Усан замын тээврийн бүртгэл, хяналтын албаны дарга Т.Олонбаяр усан замын тээврийн салбарт хэрэгжүүлж буй арга хэмжээ, аюулгүй ажиллагаатай холбоотой асуудлаар мэдээлэл хүргэв. Түүнчлэн Хөвсгөлийн тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны дарга М.Дорж тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын дэглэм, Хөвсгөл нуурын аяллын маршрутын талаар танилцуулж, аялал жуулчлал болон усан замын тээврийн үйл ажиллагааг байгаль орчны хамгаалалтай уялдуулах шаардлагын талаар мэдээлэл өгсөн.




Мөн Монгол Улсын Далайн захиргааны Усан замын тээврийн бүртгэл, хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн Ш.Долгион “Усан замын тээврийн салбарын цахимжилт, бүртгэл, тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаа” сэдвээр мэдээлэл хийж, усан замын тээврийн хэрэгслийн бүртгэл, холбогдох үйл ажиллагааг цахимжуулах, тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой хэрэгжилтийн талаар танилцууллаа.

Хөвсгөл аймгийн Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах хяналтын улсын байцаагч, дэд хурандаа Л.Бямбасүрэн “Усны ослоос урьдчилан сэргийлэх” сэдвээр мэдээлэл хийж, усны осол гарах эрсдэл, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, иргэд болон усан замын тээврийн үйлчилгээ эрхлэгчдийн анхаарах асуудлын талаар практик зөвлөмж өгч ажиллав.

Үүний дараа Хөвсгөл аймгийн Онцгой байдлын газрын эмч, сэтгэл зүйч, дэслэгч Б.Хонгорзул “Анхны тусламжийн сургалт” сэдвээр мэдээлэл, сургалт зохион байгуулж, усны осол болон бусад гэнэтийн нөхцөл байдлын үед анхны тусламжийг зөв, шуурхай үзүүлэх, осолд өртсөн иргэнд шаардлагатай тусламжийг хүргэх талаар оролцогчдод практик зөвлөмж хүргэв.

“Монголын усчин аврагчдын холбоо” НҮТББ-ын гүйцэтгэх захирал Р.Эрдэнэ-Оргил “Усчин аврагчийн сургалтыг зохион байгуулах, чадамжийн гэрчилгээ олгох талаар” сэдвээр мэдээлэл хийж, усан орчинд ажиллах аврагчийн мэдлэг, ур чадвар, сургалт, дадлага, чадамжийн гэрчилгээтэй холбоотой асуудлыг танилцуулсан. Тус мэдээлэл нь усан замын тээврийн үйлчилгээ эрхлэгч, жуулчны бааз болон усан орчинд үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын аврах ажиллагааны бэлэн байдлыг хангахад ач холбогдолтой байв.

Хөвсгөл нуур-Эгийн голын сав газрын захиргааны мэргэжилтэн Б.Оюунгэрэл “Ус, усан орчин ашиглагч иргэн, аж ахуйн нэгжид дүгнэлт, зөвшөөрлийн мэдээлэл болон Зөрчлийн тухай хуулийн талаар” сэдвээр мэдээлэл хийж, ус, усан орчныг ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг, шаардлагатай зөвшөөрөл, дүгнэлт, холбогдох хууль тогтоомж болон зөрчил гаргасан тохиолдолд хүлээлгэх хариуцлагын талаар танилцууллаа.



Мөн сургалтын төгсгөлд Усан замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын талаар хэлэлцүүлэг зохион байгуулж, оролцогчдын санал, хүсэлт, практикт тулгамдаж буй асуудлыг сонсон, усан замын тээврийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулахтай холбоотой асуудлаар нээлттэй санал солилцов.

Сургалт, семинарын хүрээнд ийнхүү усан замын тээврийн салбарын хууль эрх зүй, бүртгэл хяналт, цахимжилт, тусгай зөвшөөрөл, усны ослоос урьдчилан сэргийлэх, анхны тусламж, усчин аврагчийн чадавх, ус ашиглалт болон байгаль орчны хамгаалал зэрэг асуудлыг цогцоор нь авч үзсэн нь оролцогчдод усан замын тээврийн аюулгүй ажиллагааны талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэхэд ач холбогдолтой байв.

Түүнчлэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж буй Хөвсгөл нуурыг Төрийн тахилгат болгох тухай захирамжийн хүрээнд зохион байгуулагдсан Хөвсгөл нуурын эргийн бүсийг цэвэрлэх нэгдсэн аянд Монгол Улсын Далайн захиргааны албан хаагчид нэгдэн оролцов. Тус аянд Хөвсгөл аймгийн 7 сумын иргэд, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын төлөөлөл зэрэг 1,000 гаруй хүн оролцож, нийт 700 гаруй км эргийн бүсийг цэвэрлэх ажлыг зохион байгуулсан бөгөөд Монгол Улсын Далайн захиргааны албан хаагчид хариуцсан 70 орчим км эргийн бүсийн цэвэрлэгээний ажлыг хийж гүйцэтгэв.

Цэвэрлэгээний ажлын хүрээнд нуурын эрэг орчимд хуримтлагдсан хог хаягдлыг цэвэрлэж, байгаль орчны бохирдлыг бууруулах, Хөвсгөл нуурын экосистем, усны нөөцийг хамгаалах, нуурын эрэг орчмын цэвэр байдлыг хадгалах чиглэлээр идэвхтэй оролцлоо. Мөн усан замын тээврийн үйл ажиллагааг байгаль орчны хамгаалалтай уялдуулах, усны нөөцийг хайрлан хамгаалах, хог хаягдлыг бууруулах, иргэд, үйлчилгээ эрхлэгчдийн байгаль орчны хариуцлагыг нэмэгдүүлэх талаар мэдээлэл, зөвлөмж хүргэж ажиллав.

Томилолтын хугацаанд хэрэгжүүлсэн арга хэмжээ, сургалт, семинарын талаарх мэдээллийг олон нийтэд нээлттэй, ил тод байдлаар хүргэх, Монгол Улсын Далайн захиргааны чиг үүрэг, усан замын тээврийн салбарт хэрэгжүүлж буй үйл ажиллагааг сурталчлан таниулах ажлыг зохион байгуулав.

Усан замын тээврийн хөвөлтийн улирлын нээлтийн хүрээнд зохион байгуулагдсан сургалт, семинарт оролцож, салбарын холбогдох байгууллага, мэргэжилтнүүдийн мэдээлэл, илтгэлээр дамжуулан усан замын тээврийн аюулгүй ажиллагаа, хууль эрх зүй, бүртгэл хяналт, осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх, анхны тусламж, аврах ажиллагаа, ус ашиглалт, байгаль орчны хамгааллын чиглэлээр мэдээлэл, туршлага солилцсон бөгөөд

Хөвсгөл нуурын эргийн цэвэрлэгээний ажилд хамтран оролцож, төлөвлөсөн ажлуудыг хэрэгжүүлэн ажиллав.



### **Зургаа. Томилолтын үр дүн**

6.1. Усан замын тээврийн хөвөлтийн улирлын нээлтийн хүрээнд зохион байгуулагдсан хамтарсан сургалт, семинарын зорилго, үйл ажиллагааг ханган ажиллаж, усан замын тээврийн үйлчилгээ эрхлэгчид болон иргэдэд аюулгүй ажиллагааны талаарх мэдээлэл, зөвлөмжийг хүргэв.

6.2. Усан замын тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, байгаль орчны аюулгүй байдлыг хангах талаар оролцогчдын анхаарах асуудлыг тодорхой болгож, холбогдох зөвлөмжийг өгч ажиллав.

6.3. Хөвсгөл нуурын эргийн 70 орчим км бүсийг цэвэрлэх нэгдсэн аянд идэвхтэй оролцож, нуурын эрэг орчмын хог хаягдлыг цэвэрлэх, байгаль орчныг хамгаалах чиглэлээр тодорхой ажил хийж гүйцэтгэв.

6.4. Усан замын тээврийн салбарын үйл ажиллагаа нь зөвхөн тээврийн аюулгүй ажиллагаагаар хязгаарлагдахгүй бөгөөд усны экосистем, байгаль орчны хамгаалалтай салшгүй холбоотой болохыг сурталчлан таниулахад тус арга хэмжээ ач холбогдолтой байв.

6.5. Монгол Улсын Далайн захиргааны чиг үүрэг, үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулж, усан замын тээврийн аюулгүй ажиллагаа болон байгаль орчны хамгааллын чиглэлээр байгууллагын оролцоог нэмэгдүүлэв.

### **Долоо. Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ**

7.1. Усан замын тээврийн үйлчилгээ эрхлэгчид, иргэдэд аюулгүй ажиллагааны талаарх сургалт, мэдээллийг тогтмол хүргэх;

7.2. Хөвөлтийн улирлын хугацаанд усан замын тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сэрэмжлүүлгийг тогтмол хүргэх;

7.3. Усан замын тээврийн хэрэгслийн техникийн бүрэн бүтэн байдал, аврах хэрэгслийн хангалт, аюулгүй ажиллагааны шаардлагын хэрэгжилтэд анхаарч ажиллах;

7.4. Орон нутгийн төрийн байгууллага, усан замын тээврийн үйлчилгээ эрхлэгчид болон иргэдтэй хамтын ажиллагааг бэхжүүлж, усан замын тээврийн аюулгүй ажиллагааг хангах чиглэлээр хамтарсан арга хэмжээг тогтмолжуулах;

7.5. Хөвсгөл нуур болон бусад дотоодын усан замын байгаль орчныг хамгаалах, усны нөөцийг бохирдлоос урьдчилан сэргийлэх чиглэлээр байгууллагын оролцоог нэмэгдүүлэх;

7.6. Усан замын тээврийн аюулгүй ажиллагаа, байгаль орчны хамгааллын асуудлыг уялдуулан олон нийтэд чиглэсэн мэдээлэл, сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулах.



**Найм. Дүгнэлт**

Хөвсгөл аймгийн Хатгал тосгонд 2026 оны 06 дугаар сарын 17-19-ний өдрүүдэд томилолтоор ажиллах хугацаанд усан замын тээврийн хөвөлтийн улирлын нээлтийн үйл ажиллагааны хүрээнд “Усан замын тээврийн аюулгүй ажиллагаа” сэдэвт хамтарсан сургалт, семинарыг зохион байгуулж, усан замын тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд холбогдох хууль тогтоомж, аюулгүй ажиллагааны шаардлага болон осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл, зөвлөмж хүргэж ажиллав.

Мөн Хөвсгөл нуурын эргийн бүсийг цэвэрлэх нэгдсэн аянд Монгол Улсын Далайн захиргааны албан хаагчид идэвхтэй оролцож, хариуцсан 70 орчим км эргийн бүсийг цэвэрлэх ажлыг гүйцэтгэсэн нь байгаль орчныг хамгаалах, усны нөөцийг хайрлан хамгаалах, байгууллагын нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэхэд чиглэсэн үр дүнтэй ажил болсон.

Томилолтын хүрээнд төлөвлөсөн үндсэн ажлуудыг хэрэгжүүлж, усан замын тээврийн аюулгүй ажиллагааг хангах, осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх, байгаль орчныг хамгаалах, олон нийтэд мэдээлэл хүргэх чиглэлээр тодорхой үр дүнд хүрч ажиллав.

ТАНИЛЦСАН:

ДАРГА

М.ӨЛЗИЙ

Хянасан:

ЗУХ-ийн дарга

Т.Мөнхбаяр

Тайлан бичсэн:

ГХХАХ мэргэжилтэн

Э.Номин